Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 15-аас 2021 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор П.Содном гүйцэтгэв.

Хангал сумын Хялганат тосгоны захирагч 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 01/32 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Хялганат тосгоны үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Иргэдээ дээдэлсэн бүтээлч, чадварлаг төрийн захиргааны байгууллага болоход оршино.

Хялганат тосгоны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төр, эдийн засаг, нийгмийн бодлогын удирдлагын үйл ажиллагаа

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Хангал сумын Хялганат тосгоны захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн 3210353.1 мянган төгрөгийн 2 хувь буюу 64207.1 мянган төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 21243.1, эцсийн үлдэгдэл 40221.4 мянган төгрөг болж, 18978.3 мянган төгрөгөөр өссөн /буурсан/ байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мян. төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө				
Төрийн сангийн харилцах	21243.1	40221.4	18978.3	100
Замд яваа мөнгөн хөрөнгө				
Хадгаламж				
Дүн	21243.1	40221.4	18978.3	-

Эх сурвалж: Хялганат тосгоны 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 40221.4 мянган төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд байршиж байна. Төрийн сангийн харилцах дансны үлдэгдлийн 40196.1 мянган төгрөг нь орон нутгийн ерөнхий орлогын дансанд, 1.2 мянган төгрөг нь орон нутгийн хөгжлийн санд, 23.9 мянган төгрөг нь жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн дансанд байршиж байна.

Аудитын илрүүлэлт:

- Анхан шатны баримтын бүрдэл дутуу томилолтын зардал 206.0 мянган төгрөгийн томилолтын зардал олгосон /Захирагчийн ажлын алба/
- ОНХС-аас 0.7 сая төгрөгийг анхан шатны баримтгүй зарцуулсан /ОНХС/

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 20008.2, эцсийн үлдэгдэл 28836.7 мянган төгрөг болж, 8828.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	221.5		-221.5
Төлбөртэй үйлчилгээний авлага			0
Татаас, санхүүжилтийн авлага			0
Байгууллагаас авах авлага	4893.8	13393.5	8499.7
Хүмүүсээс авах авлага	14892.8	15442.8	550
			0
Дүн	20008.1	28836.3	8828.2

Эх сурвалж: Хялганат тосгоны 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Ажиллагчидтай холбогдсон авлагын оны эхний үлдэгдэл 221.5 мянган төгрөгийг барагдуулсан,

Байгууллагаас авах авлагын 13393.8 мянган төгрөг нь “Битачи” ХХК-тай цэцэрлэгийн хүүхдийн тоглоом худалдан авах гэрээ байгуулан төлбөрөө төлсөн боловч цар тахлын улмаас хил хаагдаж тоглоом нийлүүлэх хугацаа тодорхойгүй хугацаагаар хойшилсноос үүссэн, сум дундын ой ангийн 2893.8 мянган төгрөгийн авлага, хүмүүсээс авах авлагын 15442.8 мянган төгрөг нь ЖДҮД сан авлага байна.

Аудитын илрүүлэлт:

- Цэцэрлэгийн хүүхдийн тоглоом худалдах, худалдан авах гэрээний 1.3 дахь заалтыг зөрчин бараа бүтээгдэхүүнээ худалдагч тал хугацаандаа нийлүүлээгүйгээс авлага үүссэн

3.5.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 161017.8 сая, эцсийн үлдэгдэл 173713.1 сая төгрөг болж, 12695.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 3 Бараа материалын үлдэгдэл /мян.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	6409.7	8239.7	1830
Эм боох материал	8079.7	12848.2	4768.5
Бэлэн бүтээгдэхүүн	4762.6	4727.6	-35
Бичиг хэргийн материал	25994.7	31631.1	5636.4
Аж ахуйн материал	64939.7	61035.3	-3904.4
Сэлбэг хэрэгсэл	1692.5	1874.9	182.4
Түлш шатахуун материал	1245	1620	375
Барилгын засварын материал	3926.3	5947.7	2021.4
Хүнсний материал	21056.3	12846.2	-8210.1
Бусад хангамж	22911.3	32942.4	10031.1
Дүн	161017.8	173713.1	12695.3

Эх сурвалж: Хялганат тосгоны 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 267014.3, хандив тусламжаар 2660.5, шилжүүлгээр болон бүтцийн өөрчлөлтөөр 12242.0, бусад эх үүсвэрээс 9510.1 мянган төгрөгийн бараа материалыг авч, тайлант онд 249155.9 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулж, шилжүүлгээр болон бүтцийн өөрчлөлтөөр 16142.5, бусад болон акталж устгасан 13433.1 сая төгрөгийн хөрөнгө хасагдаж хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 12695.3 сая төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Бараа материалын тайлант оны үлэгдлийн 35.1 хувь нь аж ахуйн материал, 19.0 хувийг бусад хангамжийн материал, 18.2 хувийг бичиг хэргийн материал, 7.4 хувийг эм боох материал, 7.4 хувь хүнсний материал тус тус эзэлж байна.

Хүснэгт № 4 Бараа материалын үлдэгдэл /мян.төгрөг/

д/д	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
1	Сум дундын ой анги	2806.7	2836.7	30
2	ЗДТГ	23157.4	9232.1	-13925.3
3	Хүн эмнэлэг	19268.9	25629.9	6361
4	Цэцэрлэг	49866.7	49704.7	-162
5	Сургууль	60783.9	80676.6	19892.7
6	Соёлын төв	5134.0	5632.9	498.9

Дүн	161017.7	173712.9	12695.2
-----	----------	----------	---------

Эх сурвалж: Хялганат тосгоны 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт бараа материалын 46.4 хувь буюу 80676.6 мянган төгрөгийг ЕБС, 28.6 хувь буюу 49704.7 мянган төгрөгийг СӨБ, 14.8 хувь буюу 25629.9 мянган төгрөгийг эрүүл мэндийн төв, 5.3 хувь буюу 9232.1 мянган төгрөгийг ЗДТГ, 3.2 хувь буюу 5632.9 мянган төгрөгийг соёлын төв тус тус эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

- Бараа материалын ангилал буруу бүртгэсэн /Хүүхдийн цэцэрлэг/
- Бараа материалын тооллогоорх түлш шатах тослох материалын дүн, санхүүгийн тайлангаар илэрхийлсэн үлдэгдлийг баталгаажуулаагүй. /ЭМТ/

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 4868649.3, эцсийн үлдэгдэл 4819153.0 мянган төгрөг болж, 49496.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж	2445418.8	2471843.4	26424.6
Тээврийн хэрэгсэл	260427.7	269591.3	9163.6
Машин тоног төхөөрөмж	478753.1	411619.3	-67133.8
Тавилга эд хогшил	184099.5	174097.5	-10002
Номын фонд	16173.8	19244.4	3070.6
Бусад үндсэн хөрөнгө	1254884.9	1247027.6	-7857.3
Программ хангамж	2370.0	5070.0	2700
Бусад биет бус хөрөнгө	226521.5	220659.5	-5862
Дүн	4868649.3	4819153.0	-49496.3

Эх сурвалж: Хялганат тосгоны 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 44468.4, балансас балансад шилжүүлэн авсан 51034.6, үнэ төлбөргүй хандиваар авсан 68695.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн, балансас балансад шилжүүлсэн 35598.4, акталсан 80129.4, бусад 97966.7 мянган төгрөгөөр хасагдсан байна.

д/д	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
2	ЗДТГ	1778592.2	1771071.3	-7520.9
3	Хүн эмнэлэг	456965.2	459136	2170.8
4	Цэцэрлэг	483882.1	492979.8	9097.7
5	Сургууль	1845443.8	1803354.6	-42089.2
6	Соёлын төв	125618.6	125618.6	0
7	Сум дундын ой анги	178147.4	166992.7	-11154.7
	Дүн	4868649.3	4819153.0	-49496.3

Үндсэн хөрөнгийн 36.8 хувийг сумын ЗДТГ, 37.4 хувийг Ерөнхий боловсролын сургууль, 9.5 хувийг Эрүүл мэндийн төв, 10.2 хувийг хүүхдийн цэцэрлэг, 2.6 хувь нь соёлын төв, сум дундын ойн анги 3.5 хувийг эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

- Үндсэн хөрөнгөтэй холбоотой гарсан зөрчлийг бичихдээ ижил төрлийн зөрчлийн дүнг нэгтгэж бичээд /материаллаг том дүнтэй байгууллагын нэрс, дүнг тоочих/
- Худалдан авалттай холбоотой /тендер болон бусад/ зөрчлийг тоочих

3.5.4 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 201.2 мянган төгрөгийн өглөг барагдуулж тайлант онд өглөгийн үлдэгдэлгүй байна.

Аудитын илрүүлэлт:

- Эмийн өглөг 1126.0 мянган төгрөгийг санхүүгийн тайланд дутуу тусгасан, харилцагч байгууллагатай тооцоо нийлж баталгаажуулаагүй. /ЭМТ/
- ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн төсөл хөтөлбөрөөс 3.5 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг орлогоор бүртгээгүй. /ОНХС/

3.5.5 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 3735839.5 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 3610519.7 мянган төгрөг болж, 125319.8 мянган буурсан байна.

Хүснэгт № 31. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО /САЯ ТӨГРӨГ/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3505149.1	3505149.1	0	97.1
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/			0	
Хуримтлагдсан үр дүн	-778920.8	-904240.6	-125319.8	
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1009611.2	1009611.2	0	2.9
Дүн	3,735,839.50	3,610,519.70	-125,319.80	100.00

Эх сурвалж: Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 3610519.7 мянган төгрөг болж 125319.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Үүнд:

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 1009611.2 мянган төгрөг тайлант онд өөрчлөлт ороогүй байна.

Хуримтлагдсан үр дүн (778920.8) мянган төгрөг болж (125319.8) мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5.6 Орлогын данс

Төсөвт байгууллагуудын өөрийн орлого 20660.0 мянган төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 24680.9 мянган төгрөг оруулж биелэлт 119.4 хувьтай байна. Үндсэн үйл ажиллагааны орлогод байгаль хамгаалах санд 6062.0, ЖДҮД сан 8359.5, соёлын төв 573.5, сум дундын ойн анги 19105.0, захирагчийн ажлын алба 5575.9 мянган төгрөг орлого төвлөрсөн байна.

3.5.7 Зардлын данс

Сумын ИТХ-ын 2020 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 03 дугаар тогтоолоор сумын 2020 оны төсвийн жилд зарцуулах төсвийг 2871079.9 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 2702698.6 мянган төгрөг буюу 94.1 хувийн гүйцэтгэлтэй байна.

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Бу. Хя Орон нутгийн хөгжлийн сан	33,611.30	27,520.00	-6,091.30
Бу. Хя Байгаль хамгаалах сан	12,000.00	6,062.00	-5,938.00
Бу. Хя Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан	11,573.90	8,909.50	-2,664.40
Бу. Хя тосгон. Соёлын төв	93,875.90	85,795.51	-8,080.39
Бу. Хя тосгон. Сум дундын ойн анги	73,113.30	65,164.08	-7,949.22
Бу. Хя тосгон. Сургууль	1,350,072.60	1,285,543.00	-64,529.60
Бу. Хя. Хүн эмнэлэг	420,156.20	418,360.33	-1,795.87
Бу. Хя тосгон. Захирагчийн ажлын алба	314,351.90	311,088.45	-3,263.45
Бу. Хя тосгон. Цэцэрлэг	562,324.80	494,255.72	-68,069.08
	2,871,079.90	2,702,698.58	-
			168,381.32

Нийт төсвийн 47.6 хувь буюу 1285543.0 мянган төгрөгийг ЕБС, 18.3 хувь буюу 494255.7 хүүхдийн цэцэрлэг, 15.5 хувь буюу 418360.3 мянган төгрөгийг эрүүл мэндийн төв, 11.5 хувь буюу 311088.4 мянган төгрөгийг захирагчийн ажлын алба 2.4 хувийг сум дундын ой анги зарцуулсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Цалингийн зардлаас ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд зарцуулсан /Захирагчийн ажлын алба, сум дундын ойн анги, ЕБС/
- Сахилгын шийтгэлтэй албан хаагчид 340.6 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон /Захирагчийн ажлын алба/
- Цалингийн зардлаас нэг удаагийн тэтгэмжийг шууд зардал бичиж зарцуулсан /ЭМТ,
- ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу тендерт шалгарсан аж ахуйн нэгж байгууллагаас эмийг бэлдээгүй. /ЭМТ/

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Хангал сумын ИТХ-ын 2020 оны орон нутгийн төсөв батлах тухай 12/10 дугаар тогтоолд зааснаар Хялганат тосгоны захирагчийн тайлант онд 43677.0 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 68639.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 164.9 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
НИЙТ ОРЛОГО	43,677,000.0	68,639,451.44	24,962,451.4
ТАТВАРЫН ОРЛОГО	37,777,000.0	62,285,033.44	24,508,033.4
Хувь хүний орлогын албан татвар	24,390,000.0	44,438,316.9	20,048,316.9
Үйл ажиллагааны орлого	2,100,000.0	3,870,472.0	1,770,472.0
Хөрөнгийн орлого	13,790,000.0	20,326,731.6	6,536,731.6
Шууд бус орлого	8,500,000.0	20,241,113.3	11,741,113.3
Хөрөнгийн албан татвар	1,387,000.0	1,387,000.0	-
Бууны албан татвар	1,387,000.0	1,387,000.0	-
Бусад нийтлэг төлбөр, хураамж	12,000,000.0	16,459,716.6	4,459,716.6
Улсын тэмдэгтийн хураамж	3,000,000.0	5,066,800.0	2,066,800.0
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	9,000,000.0	11,392,916.6	2,392,916.6
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,900,000.0	6,354,418.0	454,418.0
Нийтлэг татварын бус орлого	5,900,000.0	6,354,418.0	454,418.0
Хүүгийн орлого	5,400,000.0	5,666,500.0	266,500.0
Бусад орлого	500,000.0	687,918.0	187,918.0

Давсан орлогын биелэлтийг авч үзвэл: Хог хаягдлын хураамжийн орлого нь “Эрдэнэт Булганы ЦШС” газартай гуравласан гэрээ байгуулж айл өрхөөс цахилгааны хураамжтай хамт төлөлт хийснээс орлого давсан,

Шууд бус орлого нь “Эрдэнэс таван толгой” ХХК-ны ноогдол ашиг иргэн бүрт олгосон ашгийн суутган тооцсон татвар оны эцэст орж ирсэн,

Тэмдэгтийн хураамж нь “Долоон бар” ХХК-ны тусгай зөвшөөрлийн хураамж 3000.0 төгрөгийг төвлөрүүлснээс шалтгаалан тус тус давж биелсэн байна. Сар бүр аймгийн СТСХ-т орлогын гүйцэтгэл давж биелсэн, тасарсан шалтгааны талаар мэдээг гарган өгдөг байна.

Сумын төсөвт 8 нэр төрлийн орлого оруулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр нийт дүнгээрээ 24508.0 мянган төгрөгөөр буюу 164.9 хувиар давж биелсэн, тасалсан орлого байхгүй байна. Орлогыг нэр төрлөөр авч үзвэл үйл ажиллагааны орлого 1770.5, шууд бус орлого 11741.1, хөрөнгийн орлого 6536.7, улсын тэмдэгтийн хураамж 2066.8, хог хаягдлын хураамж 2392.9 мянган төгрөгөөр тус тус давж биелсэн байна. Орлого 164.9 хувийн биелэлт байгаа нь сайн талтай хэдий ч төсвийн төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулж орлого нөөц боломж байгаа эсэхэд судалгаа хийж, төлөвлөх шаардлагатай байна.

Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2888667.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2888667.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 17587.3 мянган төгрөгөөр бууруулж 2871079.9 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 2871079.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 2859506.0 мянган төгрөгийг урсгал зардалд, 11573.9 мянган төгрөгийг эргэж төлөгдөх зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1897209.5 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 839162.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 33610.1 мянган төгрөгийн орон нутгийн хөгжлийн сангаас, 65203.0 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, үндсэн үйл ажиллагааны орлогоос 43960.0, урьд оны үлдэгдлээс 21243.0 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын тусгай зориулалтын шилжүүлгээс 1772213.7, орон нутгийн төсвөөс 827653.8, орон нутгийн хөгжлийн сангаас 27520.1, эрүүл мэндийн даатгалын сангаас 35085.1, үндсэн үйл ажиллагааны орлогоос 39675.9 төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 43960.0 мянган төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 4284.0 мянган төгрөгөөр тасарсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2702698.6 мянган төгрөг буюу 94.1 хувьтай байгаа нь хорио цээрийн дэглэм тогтоосонтой холбоотой цалингийн зардал 59775.4, байр ашиглалттай холбоотой 8775.8, хүнс 58633.2 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөц хөрөнгөөс 64074.0, дээд шатны захирагчаас 24414.8, үйл ажиллагааны хүрээнд бий болсон 305.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс эрүүл мэндийн төв цалингийн зардал 3394.7, шатахууны зардалд 75.4, эм бэлдмэлд 19796.0, хүнс 54.0 зарцуулсан, захирагчийн ажлын алба бусдаар гүйцэтгүүлэх зардалд 1065.0, бараа үйлчилгээний зардалд захирагчийн ажлын алба 64049.1, сургууль 360.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 151 мэдээллээс 121 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийн хугацаа болоогүй, 25 мэдээллийг хугацаа хоцроож, 3 мэдээллийг байршуулаагүй байна. Тухайлбал:

- Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө гүйцэтгэл, Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, биелэлт,

- Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт,
- Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр зэрэг мэдээллийг байршуулаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 10808.0 мянган төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		/сая төгрөг/ Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт							
Албан шаардлага							
Зөвлөмж	3	10808.0	3	10808.0			100
Нийт							

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 1 тусгайн сангийн нийт 7 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 байгууллага түүврээр хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 3, “Хязгаарлалттай” 1 дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 17593.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлж, 17593.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмжийг хүргүүллээ.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

Тус байгууллагын 2020 онд Шилэн дансны цахим хуудсанд 25 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, "Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө гүйцэтгэл, Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, биелэлт,", "Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт,", " Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" зэрэг мэдээллийг байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн: Шилэн дансны тухай хуулийн 4.1.3-д заалтыг хэрэгжүүлэн ажиллаж, хуульд заасан мэдээллийг цаг хугацаанд нь мэдээлж хэвших, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх, албан шаардлага өгсөн.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 48608.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 2520.0 сая төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт

тогтоож, 6139.3 сая төгрөгийн 6 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 39949.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 13 зөвлөмжийг хүргүүлээ.

Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтыг хэрэгжүүлж оны эцэст авлага, өглөггүй ажиллах, сум хөгжүүлэх сангийн зээлийг хугацаандаа төлөөгүй иргэдийн асуудлыг хууль хяналтыг байгууллагад шилжүүлж, авлагыг бүрэн барагдуулж төсвийг хохиролгүй болгох.

3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

4.1 Орлогын данстай холбоотой асуудал

4.1.1 Илрүүлэлт: Сумын төсөвт 8 нэр төрлийн орлого оруулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр нийт дүнгээрээ 24508.0 мянган төгрөгөөр буюу 164.9 хувиар давж биелсэн, тасалсан орлого байхгүй байна. Орлогыг нэр төрлөөр авч үзвэл үйл ажиллагааны орлого 1770.5, шууд бус орлого 11741.1, хөрөнгийн орлого 6536.7, улсын тэмдэгтийн хураамж 2066.8, хог хаягдлын хураамж 2392.9 мянган төгрөгөөр тус тус давж биелсэн байна.

4.1.2 Эрсдэл: Боломжит орлогууд төвлөхгүй үлдсэн байх магадлалтай,

4.1.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн орлогын биелэлтэд дүн шинжилгээ хийж, давсан орлогыг төлөвлөх боломжтой эсэх талаар судалгааг хийж, орлогын төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулах.

4.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

4.2 Авлага, өглөгтэй холбоотой асуудал

4.2.1 Илрүүлэлт: Сумын төсөвт байгууллагууд Тайлант онд Цэцэрлэг 10500.0, сум дундын ойн анги 2893.8 мянган төгрөгийн авлага нэмэгдсэн, Мөн сум ЖДҮДС-гийн сангийн зээлийн авлагын үлдэгдлээс 2 иргэний 4.2 сая төгрөгийн зээл хугацаа хэтрэлттэй байна.

Энэ нь Үнэн зөв байдал, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэснийг зөрчсөн байна.

4.2.2 Эрсдэл: Авлага, өглөгийг тухай бүр барагдуулаагүй байх.

4.2.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтыг хэрэгжүүлж оны эцэст авлага, өглөггүй ажиллах, ЖДҮД сангийн зээлийг хугацаандаа төлөөгүй иргэдийн асуудлыг хууль хяналтыг байгууллагад шилжүүлж, авлагыг бүрэн барагдуулж, төсвийг хохиролгүй болгох.

4.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

4.3 Дотоод хяналттай холбоотой асуудал

4.3.1 Илрүүлэлт: Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангаар нийт 48608.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсний 2520.0 мянган төгрөгт төлбөрийн акт тогтоож, 6139.3 мянган төгрөгт албан шаардлага бичиж, зөрчлийг давтан гаргахгүй байх 39949.1 мянган төгрөгийн зөвлөмжийг хүргүүлж, алдаа зөрчил өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байна.

Энэ нь Үнэн зөв байдал, хэмжилт гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, сангийн сайдын 55 дугаар тушаалыг тус тус зөрчсөн байна.

4.3.2 Эрсдэл: Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн материаллаг хэмжээний алдаа зөрчлийн дүн санхүүгийн тайлангийн хүлээн зөвшөөрөгдөх материаллаг байдлаас

4.3.3 Өгсөн зөвлөмж: Сумын төсөвт байгууллагуудын төсвийн захирагч, нягтлан бодогч нар, санхүүгийн албаны даргын сахилга хариуцлагыг дээшлүүлж, хууль, журмыг мөрдөж, санхүүгийн тайланг алдаагүй үнэн зөв илэрхийлж, өмнөх аудитаар гарсан алдааг давтан гаргахгүй ажиллах.

4.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2021 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

П.СОДНОМ